



## БЭЛЧЭЭРИЙН ХАРИЛЦААНЫ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

С. Бадарч<sup>1\*</sup>, Оронч<sup>2</sup>

<sup>1</sup>Эдийн Засаг Бизнесийн Сургууль, ХААИС, Улаанбаатар, Монгол Улс

<sup>2</sup>Нийгмийн шинжлэх ухааны хүрээлэн, ӨМӨЗО, БНХАУ

\* Холбоо барих хаяг: badarch.s@muls.edu.mn

### ХУРААНГУЙ

Энэхүү судалгааны гол зорилго нь бэлчээрийн мал аж ахуй дахь бэлчээрийн газрыг нийтээр ашиглах болон хувьчлан эзэмших хэлбэрийн давуу болон дутагдалтай талыг Өвөр монголын өөртөө засах орны болон Монголын бэлчээрийн мал аж ахуйн жишээн дээр онолын талаас нь судалж, боломжит хувилбарын талаар төсөөлөл дэвшүүлэхэд чиглэгдсэн болно. Судалгааны ажлын практик ач холбогдол нь бэлчээрийн талбайн эзэмшил, ашиглалт, түүний үр дүнг сайжруулахад оришино. Судалгаанд хэрэглэгдэж буй үндсэн арга зүй нь онолын хийсвэрлэл, харьцуулалт, хийсвэр сэтгэхүйн болон бодит үр дүнгийн аргад тулгуурласан болно. Энэхүү онолын судалгааны гол үр дүн нь бэлчээрийн талбайг ашиглах, эзэмших хосолмол хувилбар байж болох талаар санал боловсруулсанд оришиж байна. Судалгааны үр дүнд онолын хувьд бэлчээрийн мал аж ахуйд бэлчээрийн талбайг нийтээр ашиглах болон хувьчлан эзэмших хосолсон хэлбэр байх боломжтой гэсэн дүгнэлтэнд хүрч байна.

**ТҮЛХҮҮР ҮГС:** Бэлчээрийн мал аж ахуй, бэлчээрийн талбай, бэлчээрийн нийтийн эзэмшил, бэлчээрийн хувийн эзэмшил, бэлчээр эзэмшлийн хэлбэр

### ОРШИЛ

Монголын бэлчээрийн мал аж ахуйд 1990 онд мал сүргийг хувьчилж, зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэнээс хойш малчдад бэлчээрийг эзэмшүүлэх, өмчлүүлэх, ашиглуулах асуудал маргаантай хэвээр байгаа билээ. Энэ асуудлыг хөрш зэргэлдээ БНХАУ-ын Өвөрмонголын өөртөө засах оронд мөн үндсэн 2

хэлбэрээр туршсан туршлага, бусад орны эрдэмтэн мэргэдийн онолын үндэслэлд тулгуурлан бэлчээрийн ашиглалт, эзэмшлийн талаар онолын үзэл баримтлалыг дэвшүүлсэнд энэхүү онолын судалгааны зорилго, шинэлэг тал оришино.

### СУДАЛГААНЫ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН, АРГА ЗҮЙ

Судалгаанд хөрөнгийн өмчлөл, эзэмшил, ашиглалтын онолын харьцуулалт, зэрэгцүүлэлт, дүгнэлтийн арга зүйг ашигласан бөгөөд хөрш

орны туршлага, өөрийн орны өвөрмөц онцлогт тулгуурлан онолын дүгнэлт гаргасан болно.

### СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Судалгааны үр дүнд бэлчээрийн мал аж ахуйд бэлчээрийн газрыг нийтээр ашиглах болон тодорхой хэсгийг малчин өрхөд өмчлүүлэх

асуудлыг хослуулан хэрэгжүүлэх боломжтой гэсэн онолын дүгнэлтийг гаргасан болно.

### НЭГ: БЭЛЧЭЭРИЙН ХАРИЛЦААНЫ ОНОЛЫН АСУУДАЛ

Нэгэн улс болон нэгэн цаг үе дэх өмчлөх эрхийн тогтолцоо нь эдийн засгийн харилцааны хувьд нарийн нийлмэл шинжтэй зүйл. Түүхийн өнцөгөөс задлан шинжилгээ хийх юм бол аливаа өмчийг өмчлөх эрх нь өмчийн эзэмшлийн зохион байгуулалтын өөрчлөлтийг бий болгодог. Харин хөрөнгийн эзэмшлийн үр дүн нь зардал, орлого, ашгийн түвшин болон байрлалын ашигтай байдлаас хамаарч харилцан адилгүй байдаг.

Хөдөөгийн бэлчээрийн ашиглалтын тогтолцооны хувьсал хийгээд тогтолцооны өөрчлөлтөөс харахад хөрөнгө өмчлөх эрхийн бүтцийн төлөвлөлт, зохицуулалт нь нарийн нийлмэл, ихээхэн ээдрээтэй асуудал гэж үзэж болно. Ерөнхийд нь авч үзвэл хөрөнгийн эзэмшлийн зохион байгуулалт нь бүхий л түүхийн үе шатанд түүнээс ашиг хүртэх, энэхүү зохицуулалт нь голч шудрага, зохистой хэрэглээний харилцааг

илэрхийлэхэд чиглэж, байнга өөрчлөгдөж ирсэн болохыг ойлгож болно. Одоог хүртэл бэлчээрийн газрыг ашиглах тогтолцооны өөрчлөлт нь гол төлөв хувийн эрх мэдлээс олонхийн эрх мэдэл рүү шилжих хандлагаар явагдаж ирсэн байдаг. Мөн нийтийн эзэмшлийн байдлаас хувийн эзэмшил рүү шилжих түүхэн өөрчлөлт ч гарч байсныг тэмдэглэх хэрэгтэй. Энэ байдлыг онолын үүднээс авч үзвэл зөвхөн эдийн засгийн шинжлэх ухааны асуудал биш. Үүнээс гадна улс төр судлал болон философийн ч шинжлэх ухааны үүднээс судлах шаардлагатай хам судалгааны асуудал юм. Нийтэд эрх мэдэл байгаа хийгээд хувьд эрх мэдэл байгаа тухай уламжлалт онолын тайлбар нь түүх судлал, эдийн засаг судлал, улс төр судлал, нийгэм судлал, сэтгэл судлал гэх мэт олон салбар шинжлэх ухааны уулзварт байж л байдаг. Ерөнхийд нь авч үзвэл нийтэд эрх мэдэл байгаа нь тэгш байдал руу чиглэдэг. Хувьд эрх мэдэл байгаа нь ашиг тус руу чиглэдэг. Бодитой нийгэм эдийн засгийн тогтолцооны дотор эдгээр нь адил тэгш байж чадахгүй. Мөн ашиг тустай ч байж чадахгүй. Гэвч хоёулаа аль аль талыг бодолцох юмуу эсвэл харилцан тэнцүү байх нь хэцүү. Сүүлийн жилүүдэд бэлчээрийн эзэмшлийн тогтолцооны шинэтгэлийн цөм агуулга нь хувийн тал руугаа хүчтэй болж, нийтийн байдал нь суларч байна. Esther Mwangi нь *“Тал нутгийн бэлчээрийн удирдлага дахь хөрөнгийн эрх мэдэл ба хамтралын бий болгосон хөдөлгөөн”* хэмээх өгүүлэлдээ: “газрыг хувьчлах асуудал нь ихээхэн нарийн төвөгтэй, ээдрээтэй асуудал юм. Яагаад гэвэл бүхий л хүний хөрөнгө, эрх мэдэл харилцан адилгүй. Энэ үйл явцын дунд бүхий л хүн бүгд их л хөрөнгөтэй болохыг хүсэж таарна. Хүчтэй нь ялна. Ялагч хүн нь илүү их эд баялагт хүрэх болно. Дорой бүлэг нь байр сууриа олох нь их хэцүү. Хувьчлалын үр дүн нь нийтийн эд баялагийн залгамжит шинж чанарыг улам бүр л бүрхэгдүүлж байна. Хувьчлах нь амар биш бөгөөд зарим талаар маш хялбараар асуудлыг шийдэж болно. Тиймээс бидний дүгнэлт бол бэлчээрийн удирдлагад хамтын хөрөнгө эзэмшлийн тогтолцоог хэрэглэх нь илүү тохирно” гэж үзэж байна. **Төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооноос зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд чиглэсэн өөрчлөлт, шилжилт нь бэлчээрийн газрын ашиглалтын тогтолцооны**

**шинэтгэлийн нэг чухал орчин билээ.** Зах зээлийн эдийн засгийн гол онцлог бол тодорхой хөрөнгө өмчлөх эрхийг цогцоор хэрэгжүүлэх явдал байдаг. Энэ нь аливаа бизнесийн үр ашгийг нэмэгдүүлж, борлуулалтын өртөг, зардлыг бууруулах үндсэн нөхцөл нь болдог. Энэ өнцгөөс нь авч үзвэл бэлчээрийн мал аж ахуйд бэлчээрийн талбайг ашиглах эрх мэдэл нь уг салбарын ашгийн бодлогын нэг гол сонголт байх учиртай. **Өвөрмонголын өөртөө засах оронд одоо хэрэгжиж буй хуулиар бэлчээрийг нийтлэг эзэмших болон хэрэглэх эрх мэдэл гэж хоёр хуваадаг.** 1985 оноос хэрэгжиж буй БНХАУ-ын тал нутгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд “Тал нутаг бол бүхэлдээ төрийн өмч бөгөөд хуулинд заасан хамтын эдийн засгийн бүхий л өмчөөс бусад нь ард түмнийх болно” хэмээн заасан байдаг. Одоо хөдөөгийн малчдын дунд бэлчээрийн газрыг ашиглахдаа бэлчээрийн түрээсийн харилцааг түгээмэл ашиглаж байна. Бэлчээрийн талбайг түрээслэгч болон түрээслүүлэгчийн хооронд дараах харилцаа үүсдэг. Тухайн бэлчээрийн газрыг түрээслүүлэгч (бэлчээрийн газрыг өмчлөгч нь цөөн тооны малтай, эсвэл малгүй өрх, эсвэл бэлчээр харьцангуй сайн гэгддэг өрх) нь өөрийн эзэмшилд буй малын тоо толгойноос хэтэрсэн бэлчээртэй байх үед түрээслэгч (олон тооны малтай өрх эсвэл өөрийн эзэмшлийн бэлчээр нь доройтолд орсон өрх) өрхөд хандан бэлчээрийн талбайгаа тодорхой хугацаагаар түрээслэн нэмэлт орлого олох боломжийг ашигладаг. Өвөрмонголын өөртөө засах оронд бэлчээрийн талбайг бусдад 1-2 жилийн хугацаагаар түрээслэдэг. Түрээслэх бэлчээрийн талбайн түрээсийн төлбөр нь тухайн бэлчээрийн даацтайгаа төдийлэн хамааралгүйгээс гадна олонхи тохиолдолд түрээслэх хугацааны хувьд ч тогтсон хяналт байдаггүй. Харин бэлчээрийн талбайн түрээсийн төлбөрийн хэмжээ нь түрээслэсэн бэлчээрийн талбайн хэмжээ болон тухайн түрээслэсэн бэлчээрт байх малын тоо болон тухайн бэлчээрийг ашигласнаас олох орлогын хэмжээнээс хамаарч харилцан адилгүй өөр өөр байдаг. Түрээсийн гэрээний хүчинтэй хугацаанд түрээслэгч өрх түрээсэлж буй бэлчээрийн газраас өндөр ашиг олох зорилгоор сайн ашигладаг бол харин түрээслүүлэгч өрхийн бэлчээрийн чанар хурдан мууддаг.

### **ХОЁР: БЭЛЧЭЭРИЙН ХАРИЛЦААНЫ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА**

Бэлчээрийн газрын ашиглалтын эрх мэдлийн тогтолцоог шинэчлэх гол үндэс нь юуны өмнө “Нийтийн эзэмшил газрын эмгэнэлт жүжгийн онол” буюу хувьдаа малтай өрхийн мал маллагаа болон бэлчээрийн хамтын хэрэглээний

хоорондын зөрчилд үндэслэгдэнэ. Бэлчээрийн талбайн ашиглалтын эрх мэдлийн тогтолцооны шинэтгэлийн үндсэн агуулга нь малчин өрхийн түвшинд бэлчээрийн газрыг ашиглах эрх мэдлийн баталгаажуулалт хийгдсэн байдал болон хувийн

мал сүргийг хамтын бэлчээрт ашиглан маллаж, ашиг орлого олж буй зөрчлөөс үүдэлтэй бөгөөд энэхүү үйл явц нь сүүлийн 30 жилд өөрчлөгдөөгүй байгаа байдлаар тайлбарлагдана. Нийтийн эзэмшил газрын эмгэнэлт жүжгийн онолоор хувийн мал маллагаа хийгээд бэлчээрийн талбайн ашиглалт нийтийн байхын хоорондын зөрчлийг бий болгодог бөгөөд зөвхөн бэлчээрийн ашиглалтын хил, заагийг тодорхой тогтоох (малчин өрх хашаандаа малаа хариулж баялгийг бүтээдэг) хэрэгтэй байдаг нь бэлчээрийн газрын ашиглалтын эрх мэдлийг малчин өрх хариуцах нь дээрх зөрчлийг эерэгээр шийдвэрлэхэд хүргэдэг хэмээн тайлбарладаг. Гэвч энэхүү эрх мэдлийг хэрэгжүүлэгч малчин өрхүүд нь хүн ам, малын тоо хэт олон байх, нэг малчин өрхөд ногдох бэлчээрийн талбай бага байх, бэлчээрийн талбайн бүтэц, бүрэлдэхүүн харилцан адилгүй өөр байх гэх мэт гадаад орчны тэгш бус хувиарлалтыг бий болгох бөгөөд энэ нь хоёр төрлийн үр дагаварт хүргэдэг. Тэр нь нэгд, бэлчээрийн тодорхой талбайг малчин өрх хариуцах нь өрхийн бэлчээрийн талбайн хүрэлцээ муудах, улмаар бэлчээрийн талбай бага байснаас удаан хугацаагаар мал бэлчээрлүүлэх явцад бэлчээрийн өвс нь нөхөн сэргээгдэх боломж алдагдаж, бэлчээрийн даац хэтрэх, бэлчээрийн цөлжилт, доройтлын нэг шалтгаан болдог. Үүнээс гадна бэлчээрийг хашаалан мал сүргээ жилийн 4 улиралд зөвхөн хашаалсан бэлчээрт маллах нь эцэстээ мал, бэлчээрийн нэгэн үүсмэл хэлхээ бий болоход хүргэж байна.

Хоёрт, бага хэмжээний бэлчээрийн газарт малчин өрхүүд нь нэр төдий хуваагдахад хүрсэн ч бодит байдал дээр малчин өрхүүдэд бэлчээрийн талбайг хуваарилан эзэмшүүлэх ажил нь ихээхэн бэрхшээлтэй замыг туулсан байдаг. Үүний зэрэгцээ эцэстээ томоохон өрхүүд нь жижиг өрх болж хуваагдахад хүрсэн бөгөөд малгүй өрхийн бэлчээрийн өмчлөлийн асуудлыг шийдвэрлээгүй орхисон нь тэднийг ихээхэн хохироосон бөгөөд “нийтийн эзэмшил газрын эмгэнэлт жүжгийн онол” үргэлжлэн оршсоор байхад хүргэсэн юм. Бэлчээрийн харилцааны энэ тогтолцооны дутагдалтай талыг өөрчлөх асуудлыг авч үзэхдээ мэдээжийн хэрэг дан ганц бэлчээрийн газрын өмчлөлийн тогтолцооноос хайх нь учир дутагдалтай билээ. Бидний дэвшүүлж буй үндсэн санаа бол бэлчээрийн мал аж ахуйд нэн түрүүнд улирлын нүүдэл болон бэлчээр сэлгэж мал маллах тогтолцоог хадгалах нь бэлчээрийн газрын ашиглалтыг сайжруулахын зэрэгцээ бэлчээрийн мал аж ахуйн үйлдвэрлэлийн үр дүнг дээд хэмжээнд хүргэх явдалд үндэслэгдэж байгаа билээ. Энэхүү бэлчээрийн газрын бодит хэмжээ

болон мал аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглагдах байдлыг бэлчээр ашиглалтын зураглалаар тодорхойлж болох бөгөөд энэ нь бэлчээрийн мал аж ахуйн хувьд маш чухал өмч болно. Улирлын нүүдэл болон бэлчээр сэлгэх тогтолцооны зураглалыг тодорхойлоход тухайн бэлчээрийн хүрэн дэх малчин өрхийн тоо, малын төрөл, тоо толгой шийдвэрлэх ач холбогдолтой. Мөн энэ нь тухайн бэлчээрт хөрөнгө оруулалт хийх үндсийг бүрдүүлж өгөх болно. Бэлчээрийн талбайг эзэмших эрх мэдлийг малчдад шилжүүлэхдээ байгаль цаг уур, газар зүйн тогтоц, ургамлын бүрхүүл, эдийн засгийн нөхцөл болоод соёлын уламжлал зэрэг олон хүчин хүчин зүйлээс хамаарч түүнийг хэрэгжүүлэх арга зам нь харилцан адилгүй өөр өөр байх бөгөөд үүнд хөндлөнгөөс шууд оролцох боломжийг аль болох хязгаарлах хэрэгтэй. Харин бэлчээрийн тодорхой хэсгийг эзэмших эрхийн тогтолцооны шинэтгэлийн агуулга нь ил тод, нээлттэй байх явдал хэмээн үзэж болно. Энэ нь бэлчээрийн газрын тодорхой хэсгийг бие даасан хамт олон эзэмших эрх мэдэл хийгээд тухайн хамт олны гишүүн хувь хүний бэлчээр эзэмших эрх мэдлийг хослуулсан байхыг шаардах бөгөөд үүнийг тодорхой дүрэм, журмын хүрээнд зохицуулах боломжтой. Бэлчээрийн мал аж ахуйд бэлчээрийн талаар нэн даруй зайлшгүй шийдвэрлэх ёстой нэг асуудал бол бэлчээрийн талбайг зөвхөн өмчлөх, эзэмших эрх мэдлийг урьдал болгохоос өмнө бэлчээрийн талбайг малчдад хуваарилах, бэлчээрийн ашиглалтын эрх мэдлийг ил тод болгох, үүний агуулга, цар хүрээ, үйл явцыг зохицуулсан хууль эрх зүйн орчин шаардлагатай байгаа юм. Бэлчээрийн талбайг өмчлөх болон эзэмших, ашиглах эрхийн хооронд ижил төсөөтэй нэгдмэл юмуу эсвэл хоорондоо ихээхэн зөрөөтэй, зөрчилтэй байж болох шинжүүдийг түүний зохицуулалтанд харгалзан үзэж тусгах шаардлагатай. Дээрх эрхүүдийн нэгдмэл шинж гэдэг нь бэлчээрийн талбайн тодорхой хил, хязгаарыг тогтоох, бэлчээрийн даацад тохирсон тооны мал бэлчээрлүүлэх асуудал байх бол харин зөрчилтэй шинж нь бэлчээрийн талбайн төрөл, зүйл, хэлбэр, хэмжээ, газрын тогтоц болон усны хангамж зэрэг байж болно. “Нийтийн эзэмшил газрын эмгэнэлт жүжиг” хийгээд “хувийн эзэмшил газрын эмгэнэлт жүжиг”-ийг хэрхэн шийдвэрлэх, мал аж ахуй эрхэлж буй өрх болон бэлчээр эзэмшлийн хоорондын зөрчлийг хэрхэн арилгах нь зөвхөн практик шинжтэй бус онолын үүднээс шийдвэрлэвэл зохих томоохон асуудал болж байна. Эрдэмтэд Хардингийн “нийтийн эзэмшил газрын эмгэнэлт жүжиг”-ийн онолоор бэлчээрийг өмчлөх эрхийн тогтолцооны

шинэтгэлийг хийхдээ гол төлөв бэлчээрийг хувьчлах замаар шийдвэрлэх хандлага түгээмэл байдаг. Харин Остромын “Нийтийн усан сангийн онол”-ыг дэмждэг эрдэмтэд нь хамтаараа бэлчээр ашиглах юмуу эсвэл хамтлагийн хэлбэрийн дотоод удирдлагад түшиглэх хандлагатай байдаг бөгөөд бүлгийн дотоод зардлыг бууруулах замаар бүлгийн нэгдлийг улам нэмэгдүүлэх боломжтой гэж үздэг. БНХАУ дахь бэлчээрийн эзэмшлийн эрх мэдлийн тогтолцооны өөрчлөлтийн онцлог нь “Нийтийн эзэмшил газрын эмгэнэлт жүжиг” хийгээд “Хувийн эзэмшил газрын эмгэнэлт жүжиг”-ийн замналыг аль алиныг туулсан явдал юм. Гэвч энэхүү бэлчээрийн нийтийн болон хувийн эзэмшлийн түүхэн замналын аль нь ч төгс хувилбар байж чадаагүй юм. Тэгвэл бэлчээрийн

мал аж ахуйд бэлчээрийн эзэмшлийн төгс хувилбар нь ямар хэлбэр байж болох вэ? Гэсэн асуултанд шууд хаирулах бэлэн жор байхгүй байгаа билээ. Одоогоор бидэнд мэдэгдээд буй хувилбар нь БНХАУ-ын хувьд нарийн нийлмэл шинжтэй бэлчээрийн эзэмшлийн эрх мэдэл нь гэрээгээр зохицуулагдах хэлбэр болж байна. Төрийн зүгээс хамтын болон хувийн хэвшлийн эдийн засаг, удирдлагын тогтолцоотой уялдуулан бэлчээрийн газрын зохистой ашиглалтын тогтолцоог судлах шаардлагатай. Тэр нь хувийн хөрөнгийн эрх мэдэл, хамтын хөрөнгийн эрх мэдэл болон төрийн алсын хараат удирдлагын эрх мэдлийн хосолсон тогтолцоог бий болгоно гэсэн үг.

### ГУРАВ: СУДАЛГААНЫ ХАРЬЦУУЛСАН ҮР ДҮН, ТӨСӨӨЛӨЛ

БНХАУ-ын Өвөрмонголын бүс нутаг дахь бэлчээрийн мал аж ахуй болон Монгол улсын бэлчээрийн мал аж ахуйн үүсэл, хөгжлийн замналыг түүхийн болон хүмүүнлэгийн үүднээс авч үзвэл адил гэдгийг батлах олон эх сурвалж байгаа юм. Тухайлбал, БНХАУ-ын Өвөрмонгол дахь ардын коммуны үе дэх өмчлөлийн эрхийн тогтолцоо ба мал маллах хэлбэр нь Монгол улсын төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооны үе дэх хөдөө аж ахуйн нэгдэл, бэлчээрийн өмчлөлийн тогтолцоо болон мал маллах хэлбэр нь харилцан адил төсөөтэй байлаа. Мөн малын бэлчээрийг ашиглах хэлбэр нь сум болон гацааны хилээр зааглагдан жилийн дөрвөн улиралд сэлгэж, нүүдэллэх хэлбэр нь адил байлаа. Хэрвээ тухайн нутагт байгалийн гамшиг тохиолдвол өөр нутаг руу урт нүүдэл хийнэ. Өөрөөр хэлбэл өөр нутгаас бэлчээр зээлж ашиглах хэрэг гарна. Гэвч хүн ам, соёлын орчин, улс төрийн тогтолцоо, эдийн засгийн орчин, нэг хүнд ноогдох бэлчээрийн талбайн хэмжээ харилцан адилгүй байдлаас шалтгаалж, БНХАУ-ын Өвөрмонголын бүс нутгийн бэлчээрийн мал аж ахуй, Монголын бэлчээрийн мал аж ахуй нь аажмаар ялгаа ихтэй болж, хөгжлийн өөр өөр замыг дагах болжээ. БНХАУ-ын Өвөрмонголын бүс нутгийн бэлчээрийн мал аж ахуй нь нүүдлийн байдлаас алхам алхмаар суурин байдалд шилжихийн зэрэгцээ нүүдэллэн бэлчээрийг улирлаар сэлгэн ашиглах явдал үгүй болж, төлөвлөгөөт тогтолцоо болон бэлчээр ашиглалтын эрх мэдэл нь гэр бүл буюу өрхийн аж ахуйн түвшинд шилжсэн байна. Харин Монгол улс бол уламжлалт нүүдлийн амьдралын тогтолцоо болон бэлчээрийн хамтын хэрэглээний тогтолцоогоо хадгалж үлдсэн. Монгол улс 1990 онд зах зээлийн эдийн засгийн харилцаанд

шилжсэн ч мал сүргээ хувьчилж, бэлчээрийн газрыг нийтээр эзэмших тогтолцоо хэвээр үлдсэн юм. Гэхдээ бас төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед бэлчээрийг төлөвлөгөөтэй ашигладаг байсан тогтолцоогоо гэсэн юм. Энэ нь эцэстээ бэлчээрийг төлөвлөгөөгүй ашиглах байдалд хүргэж байна. Бодит байдалд маш олон тооны малчин өрх зах зээлдээ ойртох нэрийдлээр хүн ам олноор суурьшсан төв суурин газрын дэргэд нүүдэллэн ирж, мал аж ахуйгаа эрхлэх юмуу эсвэл усны нөхцөл харьцангуй сайн, голын хөвөө болон нуурын эргэн тойронд бууж ус, бэлчээрийг ашиглаж байна. Энэ нь тэр орчимдоо бэлчээрийн даац хэтэрч, улмаар бэлчээрийн доройтлыг бий болгоход хүргэж байна. Мөн цөлжилт үүсэх шалтгаан ч болсоор байна. Харин зам харилцаа, дэд бүтцийн хөгжил муутай, зах зээлээс хол байршдаг газар нутгийн бэлчээрт хүн ам эзгүйрч, үүнтэй уялдан бэлчээрийн газрын ашиглалт муудаж байгаа баримт түгээмэл болж байна. Монгол улсад бэлчээрийн тухай хуулийн төслийг боловсруулаад байгаа хэдий ч бэлчээрийн талбайг малчдад хэрхэн эзэмшүүлж, ашиглуулах асуудал дээр эрдэмтэд, бодлого боловсруулагчдын дунд маргаантай асуудал хэвээр байна. Японы эрдэмтэн Masamitsu “Нүүдэлчдийн ертөнц” бүтээлдээ: “Шилжин суурьших нүүдлийн нийгэмд томоохон хуримтлал, хөрөнгө гэдэг бол ямар ч ач холбогдолгүй (яагаад гэвэл байгалийн гамшиг нь гарцаагүй хөрөнгө (мал)-д нь сүйрэл авчирна) зүйл бөгөөд богино хугацаанд их хэмжээний хохирол, эсвэл томоохон үймээнийг л бүтээдэг” гэжээ. Нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг улс, орнуудын хувьд түүний эдийн засагт эзлэх хувь, хэмжээ харилцан адилгүй боловч хүн амыг хүнс, тэжээлээр хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Нүүдэлчдийн нийгэм бол нэгэн ёсны туйлын тэгш

нийгэм юм. Нүүдэлчин үндэстний сэтгэхүй нь эрхэлж буй аж ахуйгаа дагаад бусад үндэстний сэтгэхүйгээс эрс ялгаатай. Энэ талаас нь авч үзвэл үйлдвэрлэлийн гол хэрэгсэл болох бэлчээрийг хувьчлах нь эцэстээ хөрөнгийн хуримтлал болон байгалийн эх сурвалжийн мөхөл бөгөөд бас нийгмийн тэгш биш байдалд хүргэх эрсдэлтэй болохыг анхаарах ёстой. Гуравдугаар ойлголт бол өмнө дурдсан хоёр ойлголтын аль аль нь бэлчээрийг хувьд өмчилж болно гэж үздэг үзэл юм. Харин бэлчээрийн газрыг хувьчлах нь олон сөрөг үр дагаврыг бий болгодог. Мал сүргийг хувьчилсны дараа бэлчээрийг төлөвлөгөөтэй ашиглах бэлчээрийн менежментийн асуудал ихээхэн дутмаг болсон. Зуны улиралд мал сүргийг бэлчээр, ус сайтай газар малаа оторлохоо больсноос тодорхой бэлчээрт мал сүргийн нягтаршил ихэсч, ихэвчлэн гол, усны ойролцоо чийглэг газар мөн л бидний дурдан буй бэлчээрийн доройтлыг үүсгэж, “Нийтийн эзэмшил газрын эмгэнэлт жүжиг”-ийг бий болгож байна. ХХ зууны 80-аад оны үед БНХАУ-ын Өвөрмонголын мал аж ахуй эрхэлдэг бүс нутагт малын тоо толгойг өсгөхийг дэмжих бодлогын хүрээнд олон төрлийн арга хэлбэрээр засгийн газрын зүгээс томоохон малчин өрхүүдийг дэмжиж байсан. Түүхэн туршлага, сургамжаас

### ШҮҮН ХЭЛЭЛЦЭХҮЙ

Бусад орны эрдэмтдийн дэвшүүлсэн онолын үзэл баримтлал, хөрш орны туршлагад тулгуурлан бэлчээрийн газрыг нийтээр эзэмших болон хувьчилж ашигласны үр дүнг харьцуулан судалж, Өвөрмонголын өөртөө засах орны Өвөрмонголын

### ДҮГНЭЛТ

Судалгааны үр дүнд онолын хувьд бэлчээрийн мал аж ахуйд бэлчээрийн газрыг нийтээр болон

### ТАЛАРХАЛ

Энэхүү судалгааг хамтран гүйцэтгэж, гүн тусалцаа үзүүлсэн ӨМӨЗО-ны Өвөрмонголын их сургуулийн “Монгол судлалын төв”-ийн эрдэмтэн, төслийн удирдагч, профессор Оронч,

### НОМ ЗҮЙ

1. Esther Mwangi “Тал нутгийн бэлчээрийн удирдлага дахь хөрөнгийн эрх мэдэл ба хамтралын бий болгосон хөдөлгөөн” 1980
2. БНХАУ-ын тал нутгийн хууль 1985
3. Хардин “Нийтийн эзэмшил газрын эмгэнэлт жүжгийн онол” 2000
4. Хардин “Хувийн эзэмшил газрын эмгэнэлт жүжгийн онол” 2000

үзвэл малын тоо толгойг хэт өсгөхийг дэмжих бодлого нь эцэстээ нийгэмд тэгш биш байдлыг бий болгодог байна. Мөн үүний зэрэгцээ бэлчээрийн талхлагдал, экологийн сүйрлийг бий болгох нэг шалтгаан нь болж хувирдаг. Хятадын бэлчээрийн өмчлөлийн эрхийн тогтолцооны шинэтгэлийн туршлага нь Монгол улсын бэлчээрийн эзэмшлийн тогтолцооны шинэтгэлийн ирээдүйн тогтолцоог бий болгохын тулд бэлчээрийг малчин өрхүүдэд хялбар байдлаар “хувааж” болохгүй гэдгийг сануулж байна. Мөн бас “хуваахгүй” байж болохгүй. Бэлчээрийн талбайг эзэмшигчдэд хуваахгүй байх нь “нийтийн эзэмшил газрын эмгэнэлт жүжиг”-ийн туршлагыг давтаж болзошгүй юм. Нөгөө талдаа бэлчээрийг малчдад хуваах нь “хувийн эзэмшил газрын эмгэнэлт жүжиг”-ийн туршлагыг давтаж болох юм. Монгол улсын бэлчээрийн эзэмшлийн эрхийн шинэчлэл нь урт хугацааг хамрах зүйл бөгөөд байгаль, эдийн засаг, нийгэм, улс төрийн олон хүчин зүйлийн харилцан үйлчлэл дор бэлчээрийн чанар байнга хувьсан өөрчлөгдөж байгааг харгалзан бэлчээрийг эзэмших эрхийн тогтолцоо нь нийтээр эзэмших эрх болон хувьчлан эзэмших эрхийн холимог тогтолцоо байж болох юм.

их сургуулийн Монгол судлалын төвд илтгэл тавьж хэлэлцүүлсэн бөгөөд энэхүү судалгааны үр дүнгээр Япон болон БНХАУ-ын мэргэжлийн сэтгүүлд өгүүлэл нийтлүүлсэн болно.

хувьчлан эзэмших хосолсон хэлбэр байх боломжтой гэсэн дүгнэлтэнд хүрч байна.

эрдэм шинжилгээний ажилтан доктор Нэмэхжаргал, доктор Содцэцэн нарт гүн талархал илэрхийлье.

5. Остром “Нийтийн усан сангийн онол”
6. Masamitsu “Нүүдэлчдийн ертөнц” 2002 (Үндэстний хэвлэх хороо, 2002 он)
7. Монгол Улсын “Газрын тухай хууль” 2012
8. БНХАУ-ын Өвөрмонголын мал аж ахуй 2015
9. Монгол Улсын мал аж ахуйн хөгжлийн тойм 2016

## REFLECTION OF THE PASTORAL RELATION'S THEORY

S.Badarch<sup>1\*</sup> and Oronch<sup>2</sup>

<sup>1</sup>School of Economics and Business, Mongolian University of Life Sciences, Ulaanbaatar, Mongolia

<sup>2</sup>Institute of Social Sciences, Inner Mongolia, Republic of China

\*Corresponding author: badarch.s@muls.edu.mn

### ABSTRACT

*The main objective of this study is to identify the advantages and disadvantages of pastureland management as well as possession of pastureland in pasture and privatization in the Inner Mongolian Autonomous region and Mongolia. It is based on a theoretical perspective and proposing possible alternative scenarios. The objective of the study is to improve common use and possession of pastureland. The main method used in the study is based on theoretical abstraction, comparison and realistic approaches. The main outcome of the study is to identify the advantages and disadvantages of pasture land use for pastoral livestock. This theoretical study is designed to provide a holistic approach to pastureland possession. As a result of the study, conclusions suggest that pastureland can be used in combination form of the privately or publicly.*

**KEYWORDS:** Nomadic Pastoral Animal Husbandry, a grazing ground, public, ownership of pasture, private ownership of pasture, type of possessions pasture land